



FINANCOVÁNO
EVROPSKOU UNÍÍ
AZYLOVÝ, MIGRAČNÍ
A INTEGRAČNÍ FOND



MINISTERSTVO VNITRA
ČESKÉ REPUBLIKY



Poradna
pro integraci

Гадаад иргэдийн шинэ төрсөн хүүхдүүдэд зориулсан нийтийн эрүүл мэндийн даатгал

2021 оны 8 – р сарын 2-ноос эхлэн БНЧУ-д шинээр төрсөн хүүхдүүдийн даатгалд өөрчлөлт орж байна. Чех улсад удаан хугацаагаар оршин суух зөвшөөрөлтэй ээжээс (мөн аав нь байнга оршин суух эрхгүй) төрсөн хүүхдийг нийгмийн эрүүл мэндийн даатгалд даатгуулна. Даатгалын хүчинтэй хугацаа нь хязгаарлагдмал бөгөөд хүүхэд төрсөн өдрөөс эхлэн хуанлийн сарын 60 хоног хүртэл хүчинтэй байна. Энэ хугацааны дараа хүүхэд цаашид Чех улсад оршин суух тул хувийн бүрэн цогцолбор эрүүл мэндийн даатгалд хамрагдах шаардлагатай.

Шинээр төрсөн хүүхдийн даатгалыг хууль ёсны төлөөлөгч нэг удаа мөн даатгалын хугацааны явцад ямар ч үед төлнө. 2021 онд даатгалын шимтгэлийг 4104 кронаар үнэлнэ.

Хүүхдийг төрсөн гэдгийг 8 хоногийн дотор ээжийн хэн даатгуулсан эрүүл мэндийн даатгалын байгууллагад мэдэгдэх ёстой. Хэрвээ ээж нь нийгмийн эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй бол аавын хэн даатгуулсан эрүүл мэндийн даатгалын байгууллагад мэдэгдэнэ. Хэрэв аав нь ч Чех улсад нийгмийн эрүүл мэндийн даатгалгүй бол хүүхэд төрснийг БНЧУ-ын нийгмийн эрүүл мэндийн даатгалд VZP – Všeobecné zdravotní pojišťovně České republiky мэдэгдэнэ.